

Golomt Capital®

Валютын зах зээлийн ТОЙМ

ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК- Д БЭЛТГЭВ

2022.03.28

*Дотоодын зах зээл
Олон улсын зах зээл*

ДОТООДЫН ВАЛЮТЫН ЗАХ ЗЭЭЛИЙН СУУРЬ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2022 он 3 сарын 28

Ханшийн өөрчлөлт	Албан ханш	Долоо хоног	Оны эхнээс	Жил
	2,923.72	+0.372%	+2.610%	+2.594%

Товч дүгнэлт:

Өнгөрсөн долоо хоногт ам.долларын ханш төгрөгийн эсрэг 0.37 хувиар чангарлаа. Мөн дотоодын зах зээлд валютын ханшийн сулралын эсрэг бодлогын хүүг нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн бөгөөд цаашид Геополитикийн хурцадмал нөхцөл байдал үргэлжлэхгүй бол ханш тогтвортой байх хүлээлттэй байна.

Монголбанкны дуудлага худалдаа:

Өнгөрсөн долоо хоногт Монголбанк банкнуудын 100.0 сая ам.доллар худалдан авах хүсэлтийг зах зээлд нэг ханшаар нийлүүлсэн байна. Харин Монголбанк төгрөгийн своп хэлцлээр банкуудад 24.0 сая ам.долларыг нийлүүллээ.

**Ханшид нөлөөлөхүйц үйл явдал, суурь үзүүлэлтүүд:**

- 2022 оны 3 сарын 24-ний өдөр Монголбанкнаас бодлогын хүүг 2.5 нэгж хувиар өсгөж 9.0 нэгж хувьд хүргэлээ. Олон улсын нөхцөл байдал шокийн шинжтэй нөлөө үзүүлж байгаа нь эрчимтэй шийдвэр гаргахад нөлөөлсөн байна. Бодлогын хүү өссөнөөр эрэлтийн гаралтай инфляцын хэмжээ буурах, цаашлаад тухайн орны валютын ханш тогтвортой байх суурь нөхцөлийг бүрдүүлдэг.
- 2022 оны эхний 2 сарын байдлаар Монгол Улсын гадаад худалдаа 125.6 сая ам.долларын ашигтай гарлаа. Тайлант хугацаанд нийт бараа эргэлт 5.5 тэрбум ам.доллар байгаагаас экспорт 1.6 тэрбум ам.доллар, импорт 1.5 тэрбум ам.долларт хүрчээ. Гадаад худалдааны тэнцэл ашигтай гарах нь тухайн орны валютын ханш бусад валютуудын эсрэг чангарах нөхцөлийг бүрдүүлдэг.
- Монгол Улсын гадаад валютын албан нөөц сүүлийн 5 жил тасралтгүй өссөөр 2021 оны 4 дүгээр сард түүхэн дээд буюу 4.9 тэрбум ам.долларт хүрсэн. Харин 2021 оны 11 дүгээр сард 4.2 тэрбумд хүрч буурсан ба уналтын тренд үргэлжилсээр 3.9 тэрбум ам.долларт хүрлээ.


Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

ДОТООДЫН ВАЛЮТЫН ЗАХ ЗЭЭЛИЙН СУУРЬ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Гадаад валютын албан нөөц:

Монгол Улсын гадаад валютын албан нөөц сүүлийн 5 жил тасралтгүй өссөөр 2021 оны 4 дүгээр сард түүхэн дээд буюу 4.9 тэрбум ам.долларт хүрсэн. Харин 2021 оны 11 дүгээр сард 4.2 тэрбумд хүрч буурсан ба уналтын тренд үргэлжилсээр 3.9 тэрбум ам.долларт хүрлээ. ГВАН 3.9 тэрбум ам.доллар байгаа нь импортын 7 сарын санхүүжилтийг хангахуйц үзүүлэлт бөгөөд сүүлийн 3 жилийн дундаж түвшнээс 7.1 хувиар өндөр байна. ГВАН өндөр байх нь төгрөгийн ханш тогтвортой байх нөхцөлийг бүрдүүлнэ.

График 1: Гадаад валютын албан нөөц (сая ам.доллар)



Гадаад худалдаа:

2022 оны эхний 2 сарын байдлаар Монгол Улсын гадаад худалдаа 125.6 сая ам.долларын ашигтай гарлаа. Тайлант хугацаанд нийт бараа эргэлт 5.5 тэрбум ам.доллар байгаагаас экспорт 1.6 тэрбум ам.доллар, импорт 1.5 тэрбум ам.долларт хүрчээ. Гадаад худалдааны тэнцэл ашигтай гарах нь тухайн орны валютын ханш бусад валютуудын эсрэг чангарах нөхцөлийг бүрдүүлдэг.

График 2: Гадаад худалдаа (сая ам.доллар)



Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

ОЛОН УЛСЫН ВАЛЮТЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2022 оны 3-р сарын 28

	Хаалтын ханш	7 хоног	1 сар	1 жил
DXY	99.0991	0.62%	1.75%	6.64%
EURUSD	1.09897	-0.24%	-1.26%	-6.61%
USDCNY	6.38419	0.20%	1.05%	-2.92%
USDRUB	97.5	-1.36%	-6.90%	29.56%
USDJPY	124.408	4.04%	8.32%	13.27%
AUDUSD	0.75272	2.20%	3.89%	-3.03%

DXY ханшийн хөдөлгөөн:

Өнгөрсөн долоо хоногт ам.долларын ханш олон улсын зах зээл дээр голлох валютуудын эсрэг чангарлаа. Ханшийн өөрчлөлтөд дараах хүчин зүйлс голлон нөлөөллөө.

- АНУ-ын Холбооны нөөцийн банкнаас бодлогын хүүгээ 0.25 нэгж хувиар нэмэгдүүлж 0.50 хувьд хүргэлээ. Түүнчлэн АНУ-ын 10 жилийн хугацаатай засгийн газрын бондын өгөөж өсөж 2.4 хувийг давсан байна. АНУ-д хүүгийн түвшин өсөж, бондын өгөөж нэмэгдэж буй нь DXY индекс чангарахад нөлөөлсөн байна.
- Нөгөө талаас Их Британийн жижиглэн худалдааны борлуулалтын орлого 2 дугаар сард хүлээгдэж байснаасаа 0.9 хувиар доогуур буюу 0.3 хувийн уналттай гарсан. Үүний дараагаар фунт стерлингийн ханш ам.долларын эсрэг суларсан нь DXY индекс чангарахад бага зэрэг нөлөөг үзүүлжээ.
- Энэ долоо хоногт хүлээгдэж буй онцлох үйл явдлууд: 3 сарын 28-ны өдөр Монголын цагаар 21:30 цагт АНУ-ын барааны худалдааны тэнцлийн статистик танилцуулагдах бөгөөд энэ долоо хоногийн 5 дах өдөр АНУ-ийн NFP/ажлын байрны 2 дугаар сарын статистик мэдээлэл зарлагдахаар хүлээгдэж байна.

График 3 : DXY /ам.долларын индекс/-ийн 7 хоногийн лаа

Published on Investing.com, 28/Mar/2022 - 9:49:47 GMT, Powered by TradingView
US Dollar Index, United States, NYSE:DXY, W



Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

Бэлтгэсэн:



Р.Дарханбаяр

Хөрөнгө оруулалтын шинжээч

Darkhanbayar@golomtcapital.com

+976 9490 4321

Golomt Capital[®]

7012-1530
info@golomtcapital.com
www.golomtcapital.com